



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠢᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠᠭ᠎ᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/04



pdfMachine

A pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

ᠮᠠᠮᠠᠮᠠ 1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-13
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	14
Нэг. Эрүүл мэнд.....	15-16
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	17-19
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	20-23
Дөрөв. Гэмт хэрэг.....	24-25
Тав. Мөнгө, зээл.....	26
Зургаа. Төсөв, санхүү	27-28
Долоо. Үнэ	29-32
Найм. Хөдөө аж ахуй.....	33-35
Ес. Аж үйлдвэр	36-40
Арав. Байгаль орчин	41

pdfMachine

A pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2019 оны 4 дүгээр сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 04 сард 421 эх амаржиж, 423 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 43(9.3)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 43(9.9)-аар тус тус буурсан байна. 2019 оны 04 сарын байдлаар 137 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 9(7.0)-аар өсчээ.

Хүн амын цэвэр өсөлт 284 болж 2018 оны мөн үеийнхээс 52(15.5)-оор буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 6.7, нас баралт 2.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.2 пунктээр буурч, нас баралт 0.1 пунктээр өссөн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны 04 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 2 байна.



1.2 Эрүүл мэнд


2019 оны 04 сарын байдлаар 131.8 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар, 3.8 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар тус тус өсч, 5.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар буурсан байна.

2019 оны 04 сард 606 эх жирэмсний хяналтанд орсны 88.3 хувь буюу 535 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 7.1 мянган удаа гарсны 1.1 мянга буюу 15.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 1.4 хувиар өсч, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 815 хүн бэртэж, 28 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 141(14.2%)-ээр буурч, нас барсан хүний тоо 4(16.7%)-өөр хувиар өсчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 04 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 23.0 хувь, хавдар 22.6 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл 20.4 хувь, буад төрлийн өвчин 14.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 11.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 280 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 65-аар буюу 30.2 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд тэмбүү 32.4, трихонминиаз 60.7 хувь, цусан суулга 30.0 хувиар, бусад төрлийн өвчин 2.3 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.



1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 04 сарын эцэст 673 болсны 667 (99.1%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 6 (0.9%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 68 (9.2%) хүнээр буурч, өмнөх сараас 16 (2.4%) хүнээр буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 400 (59.4%) нь Сайншанд суманд, 130 (19.3%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 360 (53.5%) нь бүрэн дунд, 129 (19.2%) нь дээд, 64 (9.5%) нь бүрэн бус дунд, 44 (6.5%) нь техник болон мэргэжлийн, 43 (6.4%) нь тусгай дунд, 20 (3.0%) нь бага, 12 (1.8%) нь боловсролгүй иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны 04 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 04 сарын эцэст 3 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 155 иргэн ажилд зуучлагдан орж, 13 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 165 ажлын байрны 53 (32.1%) нь энгийн ажил, 27 (16.4%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 25 (15.2%) нь мэргэжилтэн, 16 (9.7%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 15 (9.1%) нь хөдөө аж ахуй, ой загас агнуурын ажилтан, 11 (6.7%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 7 (4.2%) нь контор үйлчилгээний ажилтан, 11 (6.7%) бусад салбарын ажлын байрны захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар






1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 04 сарын байдлаар 13756.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3251.8(31.0%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 4 сард өмнөх оны мөн үеэс 3251.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2075.4(31.4%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 504.9 (28.7%) ҮОМШӨ-ний даатгал 342.3 (31.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 236.0 (31.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны 04 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 16671.1 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2388.9 (16.7%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 12130.4 (72.8%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2391.6 (14.3%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 920.0 (5.5%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 900.8 (5.4%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 328.3 (2.0%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 04 сард нийгмийн халамжийн сангаас 19418 иргэнд 2855.5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 40 (0.2%)-өөр буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 26.7 (0.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 оны 04 сард 1256 хүн хамрагдсан нь өмнөх оноос 18 (1.4%)-оор буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 65.1 (8.9%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 901 иргэнд 247.9 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 668 иргэнд 201.7 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 6540 иргэнийг хамруулж, 211.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 10053 иргэн хамрагдаж, 1394.0 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/





1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 04 сарын байдлаар 205 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 68 хүн гэмтэж, 16 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 2 (1.0%)-оор, гэмтсэн хүний тоо 28 (70.0%) -аар, нас барсан хүний тоо 8 (2 дахин)-аар нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 (83.3%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 (66.7%)-өөр, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 (25.0%)-ээр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 24 (24.2%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4 (26.7%)-өөр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 1 (7.1%)-ээр тус тус буурч, авилгын гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 29.3 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 7.3 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 6.3 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 5.9 хувийг хүний амины гэмт хэрэг, 5.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.4 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 5.8 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 42 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 (2 дахин)-ээр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд сумдад нэмэгдэж, Айраг, Өргөн сумдад өмнө онтой адил, Мандах суманд гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1422.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1103.2 (4.5 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 338.9 (23.8%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 69 (33.7%) нь гэр орон сууцандаа, 42 (20.5%) нь согтуугаар, 17(8.3%) нь гудамж олон нийтийн газарт, 15 (7.3%) бүлэглэн, 25(12.2%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 62 (30.2%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 500 хүн саатуулагдаж, 80 хүн баривчлагджээ.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны 04 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт**2.1 Мөнгө, банк**

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 405.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 52.6 (29.4%) сая төгрөгөөр, цэвэр зарлага 394.9 тэрбум төгрөг болж 86.2 (17.9%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018-2019 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 112.5 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1616.0 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1579.9 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 2.9 (4.2%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 25.3 (25.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 4 дугаар сарын эцэст 4566.5 сая төгрөг болж, өмнөх сараас 577.4 (11.2%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2101.3 (85.2%) сая төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл 4 дугаар сарын эцэст 6526.7 сая төгрөг болж өмнөх сараас 512.2 (7.3%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1944.7 (23.0%) сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019.4 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019.4 сард



2.2 Төсөв, санхүү

2019 оны 04 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 20947.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 88.4 хувь байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 33.8 хувийг татварын, 13.9 хувийг татварын бус орлого, 52.3 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 04-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 1187.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг төлөвлөгөөнөөс 780.9 (92.1%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 04 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувь, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 3.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.7 хувь, хувцас бөс бараа, гутал 0.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.7 хувь, тээвэрийн бүлэг 0.5 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 1.2 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 6.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 3.2 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 6.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.2 хувь гэр ахуйн тавилгын бүлэг 3.1 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 6.3 хувь, тээвэрийн бүлэг 3.9 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 4.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 7.7 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 5.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 03 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)





Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015-2019 оны 04 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 929.6 мянган хээлтэгч малын 535.5 мянга (57.6%) нь 2019 оны эхний 4 сард төллөсөн байна. Эм хонины 68.9 хувь, эм ямааны 56.1 хувь, ингэний 28.9 хувь, үнээний 13.8 хувь, гүүний 8.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.9 хувь буюу 538.0 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 108.4 (25.2%) мянгаар нэмэгдсэн байна. Даланжаргалан суманд 65.2 мянга, Алтанширээ суманд 49.8 мянга, Дэлгэрэх суманд 48.1 мянга, Иххэт суманд 47.0 мянга, Сайхандулаан суманд 46.5 мянга, Айраг суманд 43.8 мянга, Өргөн суманд 39.8 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 63.2 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 404 болж, өмнөх оны мөн үеэс 5511 (93.2%) толгойгоор буурав. Нийт хорогдсон малын 46.3 хувийг хонь, 44.1 хувийг ямаа эзэлж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 04-р сард ноолуурын дундаж үнэ 100000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 16000 (19.0%) төгрөгөөр өссөн байна. Харин тэмээний шир 12.0 мянган төгрөг, адууны шир 5.0 мянган төгрөгийн ханштай байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Эрдэнэ суманд хамгийн их буюу 1600.0 мянган төгрөг, Алтанширээ, Иххэт сумдад хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1200.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 750.0 мянган төгрөг, хязаалан шар Алтанширээ, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Мандах, Хөвсгөл сумдад хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Өргөн суманд хамгийн их буюу 200.0

pdfMachine

A pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

н эр



ямааны дундаж үнэ Өргөн, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 04 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 55875.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 100996.9 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 11.4 хувиар, борлуулалт 39.9 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 6.7 хувийг төрийн, 93.3 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 6.7 хувь, компани 92.9 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 27.0 мян.ккалаар, ус түгээлт 102.2 мян.м3-аар, сувагжуулалт 28.2 мян.м3-аар, савласан цэвэр ус 110.0 мян.литрээр, талх 25.2 тонноор, нарийн боов 21.6 тонноор, бялуу 0.3 тонноор, хиам 5,2 тонноор, сүүн бүтээгдэхүүн 1.0 мян.литрээр, банш бууз 1.3 тонноор, бетон зуурмаг 1425 мян.м3-аар, шохой 8 тонноор, цемент 39.1 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

2019 оны 4 дугаар сард сарын дундаж агаарын температур Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Сайхандулаан, Улаан-уул, Сайншанд сумдын нутгаар 6.8-9.3 градус дулаан, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдад 10,6-11.7 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 24-30 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 5-12 градус хүйтэн, өдөртөө нийт сумдын нутгаар 46-51 градус дулаан байв.

4 дүгээр сард нийт сумдын нутгаар 1...3 өдөр хур тунадатай байж, 0.0...3.6 мм хур тунадас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Мандах суманд ОЖД-аас ахиу, бусад сумдын нутгаар ОЖД-аас бага бороо орсон байна.

Энэ сард салхины хамгийн их хурд Хөвсгөл суманд секундэд 20 метр, бусад сумдын нутгаар 12-19 метр хүрсэн. 10 м/с-ээс дээш салхитай 5...20 өдөр байлаа.

4 дүгээр сарын 7-ны байдлаар Дэлгэрэх суманд 8 баллын цасан бүрхүүлтэй, бусад сумдын нутгаар цасгүй байна.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хвн	63.1	68.2	69.6	69.8	100.3
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	492	410	464	421	90.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	106	115	128	137	107.0
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	386	295	336	284	84.5
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	2	3	1	2	2.0 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	4.1	7.3	2.2	4.8	2.1 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 129	1 733	741	673	90.8
- Үүнээс эмэгтэй	тоо	602	902	355	360	101.4
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	27	40	17	155	913.6
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	114	77	19	3	15.8
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	105	77	17	2	11.8
Улирлын чанартай ажлын байр	тоо	9	0	2	1	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1146	396	215	280	130.2
- 10000 хүнд ногдох	тоо	172	58	31	40	129.8
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	156	185	144	108	75.0
- 10000 хүнд ногдох ***	тоо	38	43	33	24	73.0
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	6773.8	22881.6	50146.5	55875.0	111.4
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	4422.5	49191.0	72174.5	100996.9	139.9

* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018 I-IV	2019 I-IV	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	119.5	131.8	12.3	110.3
2. Ор хоног	мян.хүн	44.0	41.5	-2.5	94.3
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	3.7	3.8	0.1	102.7
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	6.1	5.8	-0.3	95.1
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	7.0	7.1	0.1	101.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.2	1.1	-0.1	91.7
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	992	851	-141	85.8
Үүнээс: нас баралт	хүн	24	28	4	116.7
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	539	606	67	112.4
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	468	535	67	114.3
8. Амаржсан эх	хүн	464	421	-43	90.7
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	2	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	5	2	-3	

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 04 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	421	0	423	2	2
Айраг					1
Алтанширээ					
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг					
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ	1		1		
Сайншанд	324		327	2	1
Замын - Үүд	93		93		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	215	280	65	130.2
Вируст гепатит	1	0	-1	0.0
Сүрьеэ	33	33	0	100.0
Тэмбүү	37	49	12	132.4
Заг хүйтэн	69	56	-13	81.2
Трихоминиаз	28	45	17	160.7
Цусан суулга	10	13	3	130.0
Бусад	37	84	47	2.3 ²

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 04 сард

Боловсролын түвшингээр	2016 IV	2017 IV	2018 IV	2019 IV	2019 IV 2016 IV	2019 IV 2018 IV
	хүний тоо				хувь	
ДҮН	1 129	1 733	741	673	59.6	90.8
Үүнээс: Эмэгтэй	602	902	355	360	59.8	101.4
Магистр, доктор	10	7	1	1	10.0	100.0
Дээд боловсролтой	280	415	163	129	46.1	79.1
Тусгай дунд	136	178	35	43	31.6	122.9
Техник мэргэжлийн	130	163	50	44	33.8	88.0
Бүрэн дунд	385	732	440	360	93.5	81.8
Бүрэн бус дунд	148	194	31	64	43.2	206.5
Бага	32	35	4	20	62.5	500.0
Боловсролгүй	8	9	17	12	150.0	70.6

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 04 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2018 IV	2019 IV	2018 I-IV	2019 I-IV	2018 I-IV	2019 I-IV
ДҮН	741	673	43	39	767	3
Айраг	21	24	0	2	44	1
Алтанширээ	6	24	5	12	29	0
Даланжаргалан	35	21	0	7	27	0
Дэлгэрэх	20	11	2	2	7	0
Иххэт	40	13	2	1	38	0
Мандах	12	5	9	0	25	0
Өргөн	20	9	0	0	19	2
Сайхандулаан	7	12	0	0	9	0
Улаанбадрах	12	3	6	0	21	0
Хатанбулаг	17	7	0	0	28	0
Хөвсгөл	7	7	4	0	14	0
Эрдэнэ	7	7	1	4	15	0
Сайншанд	413	400	11	0	355	0
Замын - Үүд	124	130	3	11	136	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2019 оны 04 сарын эцэст

Салбарын ангилал	2018 I-IV	2019 I-IV
	Тоо	
Бүгд	59	165
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	2	15
Уул уурхай олборлох аж үйлдвэр	13	79
Боловсруулах үйлдвэрлэл		
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга		6
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар		
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	7	1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		2
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа		4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа,	9	14
Боловсрол	7	12
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	2	4
Урлаг, үзвэр,тоглоом наадам		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17	26
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл		

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2019 оны 04 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV
	Тоо	
Бүгд	59	165
Менежер		4
Мэргэжилтэн	13	25
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	9	27
Контор, үйлчилгээний ажилтан	3	7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	9	11
ХАА, ой загас агнуурын ажилтан	2	15
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	2	6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	8	16
Энгийн ажил мэргэжил	10	53
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	1

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2018 I-IV		2019 I-IV	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	43	26	155	74
Менежер			2	2
Мэргэжилтэн	9	7	24	20
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	5	5	27	10
Контор, үйлчилгээний ажилтан	3	3	7	7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	8	5	9	7
ХАА, ой загас агнуурын ажилтан			15	5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	2	1	6	1
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	2	1	15	1
Энгийн ажил мэргэжил	11	2	49	20
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	2	1	1

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2019 оны 04 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	3	2	2	1
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур				
Уул уурхай олборлолт	1			1
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ				
Тээвэр агуулахын үйл ажиллагаа				
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	1	1	1	
Боловсрол				
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2019 I-IV 2018 I-IV
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	10 504.7	13 756.5	131.0
Тэтгэврийн даатгалын сан	6 606.2	8 681.6	131.4
Тэтгэмжийн даатгалын сан	747.4	983.4	131.6
Эрүүл мэндийн даатгалын сан	1 760.8	2 265.7	128.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 089.8	1 432.1	131.4
Ажилгүйдлийн даатгалын сан	300.5	393.7	131.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага	14 282.2	16 671.1	116.7
Тэтгэврийн даатгалын сан	10 432.6	12 130.4	116.3
Тэтгэмжийн даатгалын сан	782.0	920.0	117.6
Эрүүл мэндийн даатгалын сан	2 176.1	2 391.6	109.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	651.6	900.8	138.2
Ажилгүйдлийн даатгалын сан	239.9	328.3	136.8

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2019 I-IV 2018 I-IV
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	17156	17217	100.4
Албан журмаар даатгуулагчид	14586	15289	104.8
Аж ахуй нэгж, байгууллага	7296	7786	106.7
Төсөвт байгууллага	7290	7503	102.9
Сайн дураар даатгуулагчид	2570	1928	75.0
2. Тэтгэвэр авагчдын тоо	8047	8499	105.6
Өндөр насны тэтгэвэр	5768	6135	106.4
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1195	1274	106.6
Тэжээгчээ алдсаны	516	501	97.1
Цэргийн тэтгэвэр	412	438	106.3
ҮОМШӨ*-ний	156	151	96.8
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	10 716.8	12 410.9	115.8
Өндөр насны тэтгэвэр	7 794.8	9 020.6	115.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 211.5	1 417.3	117.0
Тэжээгчээ алдсаны	533.3	591.0	110.8
Цэргийн тэтгэвэр	888.1	1 096.8	123.5
ҮОМШӨ*-ний	289.1	285.2	98.7

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2018 I-IV	2019 I-IV	2019 I-IV 2018 I-IV
	сая төгрөг		хувь
ДҮН	10504.7	13756.5	131.0
Айраг	181.4	232.8	128.3
Алтанширээ	66.9	79.1	118.2
Даланжаргалан	458.9	619.8	135.1
Дэлгэрэх	83.0	106.1	127.8
Иххэт	104.8	152.4	145.4
Мандах	130.0	102.1	78.5
Өргөн	204.8	416.8	2.0 ²
Сайхандулаан	88.2	124.2	140.8
Улаанбадрах	89.6	108.5	121.1
Хатанбулаг	182.8	191.2	104.6
Хөвсгөл	92.2	102.1	110.7
Эрдэнэ	147.5	191.3	129.7
Сайншанд	5963.1	7967.6	133.6
Зүүнбаян баг	310.8	393.9	126.7
Замын-Үүд	2400.7	2968.6	123.7

Тайлбар: ²- дахин их

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2018 I-IV	2019 I-IV	2019 I-IV 2018 I-IV
	сая төгрөг		хувь
ДҮН	14282.2	16671.1	116.7
Айраг	735.9	821.5	111.6
Алтанширээ	290.7	301.5	103.7
Даланжаргалан	578.6	776.1	134.1
Дэлгэрэх	286.4	343.5	119.9
Иххэт	537.0	601.4	112.0
Мандах	312.5	337.9	108.1
Өргөн	441.5	702.9	159.2
Сайхандулаан	207.4	244.2	117.7
Улаанбадрах	314.7	362.6	115.2
Хатанбулаг	525.0	657.4	125.2
Хөвсгөл	269.7	296.3	109.9
Эрдэнэ	481.4	549.8	114.2
Сайншанд	6096.9	7207.7	118.2
Зүүнбаян баг	533.9	616.7	115.5
Замын-Үүд	2670.6	2851.6	106.8



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-IV 2018 I-IV	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-IV 2018 I-IV
	2018 I-IV	2019 I-IV		2018 I-IV	2019 I-IV	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	19458	19418	99.8	2828.8	2855.5	100.9
1. Халамжийн тэтгэвэр	1274	1256	98.6	735.6	800.7	108.9
Ахмад настны тэтгэвэр	54	65	120.4	29.5	42.1	142.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1220	1191	97.6	706.0	758.6	107.4
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	990	901	91.0	248.2	247.7	99.8
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	930	853	91.7	232.2	231.5	99.7
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	48	40	83.3	13.5	13.4	99.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	6	100.0	1.4	2.1	148.5
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	5	2	40.0	1.0	0.6	56.8
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1			0.1	0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	863	668	77.4	188.5	201.7	107.0
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	219	167	76.3	123.5	117.9	95.4
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	624	371	59.5	41.5	32.1	77.4
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	4	123	30.7 ²	0.4	38.6	107.1 ²
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	5	6	120.0	10.0	12.0	120.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-IV 2018 I-IV	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-IV 2018 I-IV
	2018 I-IV	2019 I-IV		2018 I-IV	2019 I-IV	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	1	33.3	3.6	1.2	33.3
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	5	0	0.0	6.0	0.0	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	3	0	0.0	3.6	0.0	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0		0	0	
5. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	5971	6540	109.5	233.4	211.4	90.6
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3381	3299	97.6	60.3	59.2	98.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	136	233	171.3	17.6	24.5	138.6
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	0	0.0	2.7	0.0	0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1596	2470	154.8	74.0	58.4	78.9
Банкны шимтгэл				1.3	1.1	81.6
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	858	538	62.7	77.4	68.3	88.1
6. Бусад халамжийн дүн	10360	10053	97.0	1423.1	1394.0	98.0
Алдарт эхийн одонгийн тусламж	4620	4792		620.8	633.9	102.1
